



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/115

Мандалговь

Сайнцагаан сумын 6-р багийн иргэн  
Эрдэнчимэг овогтой Долгормаад  
тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/г/, Сангийн сайдын 2018 оны 318 тоот тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 20-ний өдрийн 5 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын 6 дугаар багийн иргэн Эрдэнэчимэг овогтой Долгормаа нь хүнд өвчний улмаас Улаанбаатар хотод 3-р шатлалын эмнэлэгт эмчилгээ сувилгаа хийлгэх шаардлагатай байдал, аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн өргөдлийг харгалзан үзэж нэг удаагийн тусламжийг үзүүлсүгэй.

Хоёр. Тусламжид шаардагдах 200000 (Хоёр зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190322